



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын сум дундын Ойн ангийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/69/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Булган аймаг 2024 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhtbayard@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 219

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН СУМ ДУНДЫН
ОЙН АНГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.ДАВААХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайланд онд өөрийн орлогын төлөвлөгөөг 4,061.1 мянган төгрөгөөр буюу 14.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд 510.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 6,886.4 мянган төгрөгийн 24 нэр төрлийн тавилга эд хогшлыг байгууллагын даргын 2023 оны А/16 тоот тушаалаар үнэ шинэчлэн тогтоож, үндсэн хөрөнгийн тайланд тайлагнажээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

006020503

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган
төгрөгөөр)

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,759.9	18,442.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	89,424.5	78,132.3
	Нийт хөрөнгийн дүн	108,184.4	96,574.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	15.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	108,184.4	96,559.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	108,184.4	96,574.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	171,667.9	91,477.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	92,786.3	109,989.3
	Үйл ажиллагааны үр дүн	78,881.6	(18,511.5)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	6,886.4
	Үйл ажиллагааны нийт үр дүн	78,881.6	(11,625.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,302.8	108,184.4
	Тайлант оны үр дүн	78,881.6	(11,625.1)
	Эцсийн үлдэгдэл	108,184.4	96,559.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	89,697.8	91,477.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	81,482.3	90,967.8
	Үйл ажиллагааны ЦМГ	8,215.5	510.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(8,215.5)	(510.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	67,261.3
	Урсгал зардал	-	67,261.3
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	67,261.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	67,261.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 105,893.9 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 105,893.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Төсвийн шууд захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны 05 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүрэлдэхүүн, иж бүрдлийг хангаж ирүүлээгүй,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан нийт 105,893.9 мянган төгрөгийг залрууллаа.

Аудитаар нийт 600.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 600.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1 зөвлөмжийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 791.8 мянган төгрөгөөр бага тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тээвэр шатахууны зардлыг зарцуулахдаа норм нормативыг баримтлаагүй зарцуулсан нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал баталсан "автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан бараа материалыг тухай бүр орлогод авч, норм нормативаар зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн шууд захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны 05 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүрэлдэхүүн, иж бүрдлийг хангаж ирүүлээгүй.	1	102,208.8	1	102,208.8			1	102,208.8				
Санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.	1	3,685.0	1	3,685.0			1	3,685.0				
Дүн	2	105,893.8	2	105,893.8			2	105,893.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн											
Тээвэр шатахууны зардлыг зарцуулахдаа норм нормативыг баримтлаагүй зарцуулсан.	1	600.0					1	600.0					
Дүн	1	600.0					1	600.0	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд 159 мэдээлэл байршуулахаас мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн, өмч хөрөнгө захиран зарцуулсан 5 шийдвэрийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 49,918.5 мянган төгрөгийн 7 гүйлгээ, зарлагын 43,385.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх онд өгөгдсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1				1	-		
Дүн	1	-			1	-		
Нийт дүн	1	-			1	-		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10

1	Хутаг-Өндөр сумын Сум дундын ойн анги	1	1			1			
	ТШЗ-ийн дүн	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			